

**“ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН 250 КМ ХҮНД ДААЦЫН  
ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ-БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ (DBOT) КОНЦЕССЫН  
ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

Энэхүү Гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 5.3 дахь заалт, концесс эзэмшигч “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-ийн 2019 оны 1/27 дугаар албан тоотоор ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн нэг талаас Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нэгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Болор-Эрдэнэ /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү Нэмэлт гэрээг байгуулав.

### **НЭГ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1.1. “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 1.34.2 дахь “Энэхүү Гэрээний 1.14-т заасан төслийн нийт хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх ам долларыг концесс эзэмшигчийн Монгол Улсын арилжааны банкин дахь өөрийн дансанд байршуулсан нотлох баримтыг ирүүлсэн байх;” гэсэн заалтыг “Төсөлд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн мөнгөн гүйлгээ, түүнтэй холбоотой гэрээний нотлох баримттай байх;” гэж өөрчлөн найруулав.

### **ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

2.1. Энэхүү Нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Энэхүү Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 3 хувь үйлдэгдсэн бөгөөд концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:  
Гарын үсэг: .....  
  
Нэр: Б.Баярсайхан  
Албан тушаал: Үндэсний хөгжлийн  
газрын дарга  
Тамга:

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ: УЛААНБААТАР ХОТ  
Гарын үсэг: .....  
  
ТАЛ НУТГИЙН  
ХӨГЖЛИЙН ЗАМ  
ХХК  
Нэр: Б.Болор-Эрдэнэ  
Албан тушаал: Гүйцэтгэх захирал  
Тамга:  
1119278301 СТС1004 6394426